

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ, ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ, “ЭРДЭНЭС
ТАВАНТОЛГОЙ” ХК, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:


“17.8.Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил
дамнасан төмөр замыг бүтээн байгуулах ажлын явцын талаар Зам, тээврийн сайд
Б.Дэлгэрсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг Засгийн газрын
холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав:

1.Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн
айлчлалын үеэр 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хятадын талтай хийсэн
хэлэлцээний протоколыг баталгаажуулах арга хэмжээ авахыг Аж үйлдвэр, эрдэс
баялгийн сайд Ц.Туваанд;

2.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Чайна энерги групп” компаниас тавьж
байгаа нүүрсний чанарын үзүүлэлтийн ангилал болон хоёр талын нүүрсний
лабораторийн шинжилгээний дүгнэлтийн зөрүүг тооцох аргачлалыг 2024 оны
11 дүгээр сарын эхний хагаст багтаан хятадын талтай хэлэлцэн тохирох арга
хэмжээ авахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, “Эрдэнэс Тавантолгой”
ХК (Х.Мөнхжаргал) нарт;

3.“Чайна энерги групп” компаниас ирүүлсэн Гашуунсухайт-Ганцмод
боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрс худалдах-худалдан
авах, нүүрс олборлох хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг цогцоор шийдвэрлэх
саналыг судалж, танилцуулах, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль
тогтоомжийн төслийг боловсруулан 2024 оны 11 дүгээр сард багтаан Засгийн
газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан,
Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан нарт.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР